

ГЭРЛЭГЧДИЙН ӨРГӨДЛИЙН ЗАГВАР:

ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАРТ

Хүсэлт гаргах нь:

Харчин овгийн Бадралын Уранчимэг би 1984 оны 7 сарын 24 өдөр Завхан аймгийн Улиастай суманд төрсөн. Монгол Улсын иргэн бөгөөд Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 6 хорооны 33а байрны 14 тоотод оршин суудаг.

Би ХБНГУ-ын иргэн Таларовски Тим Марко /1973.06.07/-той (гадаад паспортын дугаар) 2016 онд Швед Улсад ажиллаж байхдаа танилцаж, улмаар хайр сэтгэлийн холбоотой болж 2018 оноос хамтран амьдарч байна.

Энэ гэрлэлт миний анхны гэрлэлт бөгөөд сүйт залуугийн маань 2 дахь гэрлэлт юм. Би нэг, сүйт залуу маань хоёр дагавар хүүхэдтэй, дундаасаа төрсөн 1 хүүхэдтэй.

Герман хэлийг сайн эзэмшсэн тул нөхөртэйгээ харьцахад ямар нэг хэлний бэрхшээл гардаггүй. Бид гэрлээд Монгол улсад амьдрах төлөвлөгөөтэй байна.

Бидэнд Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан гэрлэхэд харшлах шалгаан байхгүй.

Бид хайр сэтгэлийн холбоогоор сайн дурын үндсэн дээр гэр бүл болж байгаа тул бидний гэрлэлтийг бүртгэж өгнө үү.

Бидний гэрлэлтийг эцэг, эх болон ах дүүс, төрөл садан бүгд хүлээн зөвшөөрч дэмжиж байгаа бөгөөд гэрчээр ээж Тунгалаг оролцох болно.

Хүсэлт гаргасан:

Холбогдох утасны дугаар:

.....оны.....сарын.....өдөр

ГЭРЧИЙН ӨРГӨДЛИЙН ЗАГВАР:

ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАРТ

Хүсэлт гаргах нь:

ХБНГУ-ын иргэн Таларовски Тим Марко болон Харчин овгийн Бадралын Уранчимэг нарын гэрлэлтийг эцэг, эх болон ах дүүс, төрөл садан найз нөхөд бид бүгд хүлээн зөвшөөрч дэмжиж байгаа бөгөөд гэрчээр Б.Уранчимэгийн ээж Тунгалаг (регистрийн дугаар бичих) би оролцох болно.

Хүсэлт гаргасан:

Холбогдох утасны дугаар:

.....оны.....сарын.....өдөр